

МАНМИН МЭДЭЭ

№ 34 2013 оны тавдугаар сарын 5

GCN Телевиз 2013 он NRB Үндэсний Христчин Нэвтрүүлгүүдийн үзэсгэлэн яармаг, чуулга уулзалтанд оролцов.



Бүх хүнийг аврахыг хүссэн тэмүүлж буй Бурханы агуу хайрыг харуулсан GCN телевизийн хөтөлбөр. Үзэсгэлэнгийн үеэр GCN телевизийн танилцуулах байранд зочилсон NRB-ийн захирал Франк Врайд (баруун талд).

Дэлхийн 170 оронд Бурханы эрх мэдэлт хүч болон Есүс Христийн хайрыг цацдаг GCN (ЖиСиЭн) телевиз нь Христэд итгэгчид жил бүр цуглардаг дэлхийн хамгийн том уулзалт болох NRB Олон улсын Христчин телевизүүдийн 70 дахь удаагийн үзэсгэлэн яармаг, чуулга уулзалтанд амжилттай оролцлоо. Чуулган 2013 оны 3 сарын 2-5ны хооронд Америкийн нэгдсэн улсын Нашвил (Nashville) хотын Оприланд дах Конвэйншн Төв, Гэйлорд Оприланд зочид буудалд зохион байгуулагдлаа.

2013 оны 3-р сарын 2 ны чуулга уулзалтын нээлтийн ёслолд NRB-ийн ерөнхийлөгч доктор Фрэнк Врайт Америк дах Хрисэд итгэгчид сүнсний хувьд зогсонги байдалд ороод байгаа болон шашины эрх чөлөөнд хязгаарлалт хийж байгааг дурдаад цаашид Христчин телевизүүдийн хамтын үйл ажиллагаа нь нэн чухал болохыг онцлон тэмдэглэв. Раул Рис пастор, доктор Тони Эванс нар гэм нүгэлээ хаяж, зүрх сэтгэлээ ариусгах, Бурханы Үгийг амьдралдаа хэрэгжүүлэх нь маш чухал болохыг ярьсан.

GCN (ЖиСиЭн) телевизээр “Тэнгэрийн орон” сэдэвтэй HD технологи, 3D-гээр хийгдсэн Манмин Төв Сүмийн И Жэй Руг тэргүүн пасторын

сургаалууд, Манмин Төв Сүмийн 30 жилийн ойн баярын урлагын тоглолт, дахин амилсаны баярын тоглолт зэргийг үзүүлээ. Мөн И Жэй Руг пасторын номнууд, Муан амтат усны хүч чадал зочдын анхаарлыг ихэд татлаа. И Жэй Руг пасторын залбирлаар далайн шорвог уснаас амтат ус болон өөрчлөгдсөн Муан амтат ус бол эмчилж эдгээх чадалтай бөгөөд итгэлээрээ хандсан хэн бүхэн хариултаа бүрэн авсаар байгаа билээ. Чуулганд оролцогч телевизийн ажилчид болон зочдын халуун уур амьсгал дунд хөл хөдөлгөөн ихтэй байлаа.

GCN (ЖиСиЭн) телевиз авралын зарын гайхамшигийг бодиттой танилцуулав. Библийн эш үзүүлэгийг тайлбарлагч мэргэжилтэн пастор Жон Мэгтирнан доктор GCN (ЖиСиЭн) телевизийн танилцуулах байранд зочилохдоо “Бурханд итгэх баталгаа гэдэг нь ариусах, сүнсний зогсонги байдлыг болон хүмүүст тохиолдож байгаа хүнд хэцүү асуудлуудыг шийдвэрлэх гол түлхүүр юм” гэж хэлжээ.

Вижн (AM 540) радиогоос ирсэн Эдгар Кажис пастор “Сүмийн итгэгч нарын хамт Энлас Телевизээр явсан Манмин Төв Сүмийн мөргөлд оролцон, ариун сургаалыг сонсож, их ивээл авлаа” гэж хэлжээ.

WFHL (FM 88.1) радиогийн захирал Манувэл Ферера доктор Муан Амтат усаар дамжуулан авсан ивээл, эдгэрлийн талаар сонсоод энэхүү гайхамшигт усыг өөрийн радиогоор сонсогчдод танилцуулах чин хүсэлтэй байгаагаа илэрхийлэв.

Онцгойлон NRB-ийн удирдлагууд хамтран ажилласанд мөн идэвхи санаачлагатай сайн оролцсон И Жэй Руг пастор болон Манмин Сүмийн итгэгчдэд гүн талархал илэрхийлэв.

Энэхүү үйл ажиллагааны үеэр GCN телевиз нь Нью Йоркийн Лайф Зон телевиз, Румины Кредо TV, Вижин Радио болон Яахова TV зэрэг 8 байгуулалатай хамтран ажиллах гэрээ байгууллаа. Мөн Балканы хойгийн Шайнинг Лайт цуглааны Слободан Криствиски пастортой Зүүн Европын бүс нутаг дахь Авралын зарын талаар санал бодлоо сольж зөвлөлдөв.

GCN (ЖиСиЭн) телевизийн ажилчид “Орчин үеийн мобайл технологийг ашиглан Авралын зарыг түгээхдээ ухаалаг гар утас зэрэг шинэ хэрэгсэлийг ашиглан хаана ч, хэзээ ч олон хүмүүст амьд үгийг үр өгөөжтэй хүргэн, дамжуулж чаддаг болсондоо үнэхээр их баяртай байна” гэж хэлжээ.

Улаанбаатар Манмин Сүм

Мөргөлийн цагийн хуваарь

Мөргөл	Цаг
Хүндэтгэлийн их мөргөл	Ням гариг 10: 30
Үдээс хойшхи мөргөл	Ням гариг 11: 30
3 дахь өдрийн мөргөл	Лхагва гариг 18: 00
5 дахь өдрийн мөргөл	Баасан гариг 21: 30
Хүүхдийн цуглаан	Ням гариг 09: 00
Сурагчдын цуглаан	Бямба гариг 15: 00
Залуучуудын цуглаан	Мягмар гариг 17: 00

залбирал цагийн хуваарь

Ангилал	Цаг	Удирдагч
Үүрийн залбирал	05:00-06:00	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Өглөөний залбирал	Даваа-Баасан 09:30-10:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Оройн Даниел залбирал	Өдөр бүр 18:00- 19:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч

Манай хаяг:

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 12-р хороо, Хангайн 3-57 тоот Улаанбаатар Ариун баярт мэдээ чуулган

Чуулганы утас: 976-11-351437

Чуулганы хариуцсан төлөөлөгч:
Г. Анхбаяр СМТ 976-91173712
976-91615337

Е- шуудан : power3712@gmail.com

Mongolian

МАНМИН МЭДЭЭ

Published by Манмин Төв Сүм

235-3 Гуро-Здонг, Гуро-гу, Сеул,
152-848 Солонгос Улс
Утас: 82-2-818-7047 • Факс: 82-2-2818-7048
http://www.manmin.org/english
www.manminnews.com
e-mail: manminministry@hotmail.com
Нийтлүүлэгч: Жаерок Лее
Редактор: Геумсун Вин

Хайр бол дөлгөөн сэтгэл юм

“Хайр бол тэвчээртэй, энэрэнгүй юм. Хайр агаархдаггүй, бардам зан гаргадаггүй, ихэрхдэггүй” (1 Коринт 13:4).



Доктор И Жей руг Тэргүүн Пастор

Америкийн сэтгэл судлалын доктор Хару Фредерик Харлов өөрийн туршилтандаа бяцхан сармагчингуудын ээжийг нь орлон өсгөх хоёр төрлийн сармагчин хэлбэртэй машин бүтээжээ. Энэ хоёр төхөөрөмж нь хоёулаа сүү өгөх үүрэгтэй. Тэдний нэгийг нь төмөр утсаар нөгөөг нь зөөлөн даавуугаар хийж өмнө нь сүү тавжээ. Эхний өдөр сармагчингууд хоёр хиймэл сармагчингийн өмнөх сүүг ялгалгүй уужээ. Дараа өдрөөс эхлэн төмөр утсаар хийсэн сармагчин руу нэг ч сармагчин очсонгүй харин зөөлөн дулаахан даавуун сармагчин дээр цугларжээ.

Энэ нь амьтад хүртэл хүйтэн хөндий, хатуу ширүүн зүйлээс зугтаж зөөлөн дулаан руу тэмүүлж байдагыг харуулж байна. Бүх бүтээлүүдийн эзэн гэж нэрлэгдсэн хүн ч мөн адилхан юм. Хүйтэн хөндий, хатуу сэтгэлтэй хүнээс сайхан сэтгэлтэй, хүнийг илүүд үзэж, тийм хүний хажууд амарч, амар тайван байдлыг мэдэрч чаддаг.

1. Хүн бүрийг өөртөө татдаг зөөлөн дөлгөөн сэтгэл

“Дөлгөөн сэтгэл” гэдэгийн сүнслэг ухагдахуун нь чин сэтгэлээсээ бүх хүнийг өөртөө агуулж, хайрлаж, олон хүнд амар тайвныг өгдөг сэтгэл юм. Ойлгоход хялбарханаар хөвөнтэй зүйрлэж болно. Хөвөн рүү хатуу зүйл шидсэн ч ямар ч дуу гардаггүй ба харин ч зөөлөн дулаанаараа өлгийдөн шингэж авдаг.

Мөн дөлгөөн сэтгэлийг олон хүмүүс доор нь амарч тухлахад тохиромжтой олон навчистай, том сайхан сүглэгэр модтой зүйрлэж болох юм. Халуун зун хурц нарны гэрлээс зугтаж, хөлсөө сэврээж, сүүдэрт нь амрах гэж цуглардагтай зүйрлэж болох юм.

Дэлхийн хүмүүс уурласан ч уураа гадагш нь гаргадаггүй дотроо хадгалдаг, дуугүй хүмүүсийг эсвэл үзэл бодлоо хүнд тулгадаггүй хүнийг дөлгөөн хүн гэж үздэг. Гэхдээ хүний боддог дөлгөөн байдал ба Бурханы хүлээн зөвшөөрдөг дөлгөөн

сэтгэл хоорондоо өөр ойлголт юм. Хичнээн даруухан, цайлган сэтгэлтэй, эелдэг зөөлөн харагдавч Бурханы хүлээн зөвшөөрсөн сайн сайхан биш бол энэ нь дөлгөөн сэтгэл болж чадахгүй юм.

Түүнчлэн даруу хүлцэнгүй мэт, зөөлөн зан чанартай, хүний үгийг сайн дагадаг юм шиг боловч сэтгэлдээ тавгүйтэж, оволзож буй уур хилэн, дургүйцэл, гомдлоо дарж, тэвчин өнгөрөөхийг дөлгөөн сэтгэл гэж хэлэх боломжгүй юм. Энэ нь сэтгэл дотроо байгаа хорон муу, ёс бус зүйлээ хаялгүй зөвхөн дарж, биеэ барьж байгаа л хэрэг юм.

Жинхэнэ дөлгөөн сэтгэлтэй хүн бол сэтгэлдээ муу муухай зүйлгүй, хорон муу, ёс бус зан чанаргүй, мэргэн ухаалаг бөгөөд хичнээн хорон муу хүнийг ч сүнслэг хайраар хайрлаж чаддаг. Гэхдээ энэ нь бусдын буруу зүйлийг ямар ч болзолгүйгээр шууд уучилж, өршөөгөөд байна гэсэн үг биш л дээ. Зарим тохиолдолд бид бүхэн эелдэг даруу байдлаар бусдыг зөв замаар дагуулах хэрэгтэй болдог. Тэгэхээр сүнслэг дөлгөөн сэтгэл гэдэг бол зүрх сэтгэл дотроо дөлгөөн бөгөөд үүний хамт гадна талаараа ч хайр халамж боломж ба ачлалт чанарын агуулсан байхыг хэлдэг.

2. Дөлгөөн сэтгэлийг бий болгох хүчин зүйл нь ариун байдал мөн

Сүнс зүгийн дөлгөөн сэтгэлтэй болохын тулд бид хамгийн түрүүнд зүрх сэтгэлдээ байгаа хорон муу, ёс бус зан чанараа хаяж, цэвэрхэн болох хэрэгтэй. Дөлгөөн даруу хүн нь хөвөн мэт учраас хэн нэгэнтэй сөргөлдөх юм болохгүй өөрт нь хичнээн их төвөг удаж, хор хохирол учруулсан ч зөрчилдөж, тэмцэлдэхгүй дуугарахгүйгээр үл барам зөөлөн дулаан, халуун сэтгэлээр өвөрлөдөг юм. Тэдний сэтгэлд нь хорон муу зан чанар байхгүй учраас бусадтай хэрэлдэж маргалдаж, төвөг учруулдаггүй.

Хэрэв бидний зүрх сэтгэлд үзэн ядалт, агаа жетөө, хардалт, өөрийгөө зөвтгөх, амин хувиа хичээх зэрэг муу зан чанар байвал бусдыг өвөрлөж ч хайрлаж ч чадахгүй. Хайр, халуун сэтгэлээр өвөрлөхийн оронд харин ч бүр эв нэгдэл хагалдаг бөгөөд төмөр, чулуу зэрэг хатуу биетийг цохиход ойж, хангинах дуу гарч, хагарах, сэв үлдэхтэй адил хүн ч гэсэн жаахан эвгүй байдалд орвол сэтгэл нь шархладаг. Бид бусдыг буруутгах, гэм буруу, алдаа дутагдлыг нь шүүн дүгнэж шивэр авир ярилцдаг.

Зүрх сэтгэл дотор нь худал хуурмаг, ёс бус байдлаас болж зүрх сэтгэлээ сайн сайхан, үнэн зөвөөр дүүргэж, өргөн болгож чаддаггүй. Ийм хүн нь өчүүхэн богино ухаантай, явцуу бодолтой, бөгөөд түргэн уурладаг. Тиймээс дөлгөөн сэтгэлтэй байхын үндсэн гол шалгуур бол хорон муу, ёс бус зан чанаргүй байх явдал юм.

Бурхан заавал ариун байдлыг олж байж

л тухайн хүнийг дөлгөөн сэтгэлтэй хүн гэж хүлээн зөвшөөрдөг. Бидний зүрх сэтгэлд хорон муу зан чанаргүй болох үед бусдыг зөвхөн хайр ба сайн сайхан талаас нь л хардаг.

Дөлгөөн сэтгэлтэй хүн ямар ч нөхцөл байдалд бусдыг энэрэн нигүүлсэх, хайрлах сэтгэлээр л хардаг. Хэн нэгнийг буруутгаж шүүх явдал байхгүй учраас атгаг хүн байсан ч тэрхүү халуун дулаан сэтгэлд хайлдаг. Мөн түүнчлэн төгс ариусвал Ариун Сүнсний удирдан замчилснаар бусдын нөхцөл байдлыг ялган таньж, хамгийн зөв замаар замчилж удирдаж чаддаг.

3. Дөлгөөн сэтгэлийг улам төгс болгодог ачлалт сэтгэл

Толь бичгээс харвал ачлалт сэтгэл гэдэг нь “Зөв шударга байдалд аливааг уужуугаар ойлгох сэтгэл болон үйлдэл бөгөөд зөвт хүний ёс журамд нийцэж байх” гэжээ. Сүнсний хувьд ч адилхан юм.

Ийм хүн нь зөвт, үнэнч шударга, ёс зүйд нийцсэн байдаг. Бусдыг ямар нэгэн байдлаар хүч хэрэглэж сөхрүүлдэггүй. Зөв үг, үйлдлээр бусдын сул талыг ойлгож засан залруулах нь олон хүний сэтгэлийг татаж чаддаг. Тиймээс хүмүүст итгэл өгвөл өөрөө хайрлуулдаг.

Дөлгөөн байдлыг улам төгс ачит сэтгэл нь бидний өмссөн хувцастай адилхан юм. Хичнээн алдартай, төгс хүн байлаа ч бохир, ноорхой хувьцастай байвал зэрэг зиндаа нь унадаг. Үүнтэй адил зан байдал нь дөлгөөн боловч гадна талаараа сайн үйлс ачлалт байдал хамтад нь л авч явахгүй бол дотоод дөлгөөн дулаан сэтгэл нь гүйцэд илэрч чадахгүй юм.

Түүнчлэн дөлгөөн сэтгэлтэй боловч түүний үг яриан дотор нь хэрэггүй хоосон үг байгаа бол бусдыг залхаадаг. Хэдийгээр энэ нь хорон муу хүн биш ч гэсэн боловч тэр хэмжээгээр харьцах, илэрхийлэх ёс зүй, хүмүүжил дутагдаж байгаа ба тэр хэмжээгээр түүнд итгэж найдах байдал буурдаг. Мөн даруу дөлгөөн боловч муу зүйл санах, бусдад хор хүргэхгүй боловч бусад хүмүүст идэвхитэй санаа тавих юм уу тусалж дэмжих, өөртөө агуулах сэтгэл байхгүй бол тэр хэмжээгээр дутагдалтай юм. Өөрөөр хэлбэл ачлалт сэтгэл дутагч байгаагийн шинж юм.

Хэрэв Есүс шавь нартайгаа хамт эргэн тойрны хүмүүстэй тоглоом шоглоом хийж хайш яаш хувцаслаж гутлаа чирж явдаг байсан бол ямар байх байсан бол? Хүмүүсийн хүндлэлийг хүлээхэд хэцүү байх байсан байх. Харин Есүс гадна төрхөөсөө эхлээд сүнслэг сүр жавхлантай, эрх мэдэлтэй байсан ба шавь нар болон бусад хүмүүс ч Түүнтэй хамаа замбараагүй хандаж чаддаггүй байсан юм. Энэ нь Матай 12:19-д бичигдсэнчлэн “Тэр мэтгэлцэхгүй,

хашхирахгүй бөгөөд гудамжнуудад хэн ч Түүний дууг сонсохгүй” гэсэн байдаг.

Хэдийгээр их балтай цэцэг байвч өнгө нь харагдахгүй, үнэр нь ялгарахгүй бол зөгий олж очиход амаргүй байдаг. Үүнтэй адил хэдий даруу дөлгөөн боловч хэл яриа, үйлсээрээ сайн зүйлийг хийхгүй бол хүмүүс түүнийг нь мэдэхгүй чигээрээ үлдэж дөлгөөн сайхан сэтгэл нь бүрэн дүүрэн гэрэлтэж чадахгүй. Үүний эсрэгээр хэл яриа, үйл хөдлөлөөрөө сайн үйлс, халамжтай мэт харагдавч дотроо дөлгөөн биш бол гаднах өнгөн байдлаас хэтрэхгүй зүгээр л дүр эсгэсэн хэрэг болно.

4. Дөлгөөн сэтгэлтэй хүний авах ивээл, ерөөл

Зүрх сэтгэлдээ ариуслыг олж, сайн үйлсэг хичээн, зүрх сэтгэлээ дөлгөөн байдлаар дүүргэвэл бидэнд ямар ивээл ирэх болоо? Матай 5:5-д “Дөлгөөн хүмүүс ерөөлтэй ээ! Учир нь тэд дэлхийг өвлөн авах болно” гэсэн бол Дуулал 37:11-д “Тэрээр өгтөн үүлсийг ч чийгээр дүүргэдэг. Тэрээр Өөрийн үүлсийг гялбуулдаг билээ” гэж сургажээ.

Энд “дэлхий” гэдэг нь тэнгэрийн орны амьдрах газрыг хэлж байгаа бөгөөд “дэлхийг өвлөх” гэдэг нь Тэнгэрийн улсад гайхалтай эрх мэдэл нэр хүндтэй болно гэсэн үг. Яагаад гэвэл даруу дөлгөөн сэтгэлтэй хүн Бурханы сэтгэлээр хүмүүсийг хайрлаж, хүчийг өгдөг учраас юм. Ингэж даруу дөлгөөн болох тусам бид илүү олон хүнийг өвөрлөж, тэднийг аврал руу замчлан удирдах боломжтой юм.

Мөн бид илүү олон хүнийг өвөрлөнө гэдэг нь бид өөрсдийгөө даруу болгож бусдын төлөө үйлчилнэ гэсэн үг юм. Тэнгэрийн орны эрх мэдэл бол бусдад үйлчилдэг, даруу дөлгөөн хүмүүст өгөгддөг юм. Яг Матай 23:11-д “Харин та нарын дундах хамгийн агуу нь зарц болог” гэж сургасан байдагтай адил та бусдад үйлчилвэл тэнгэрийн оронд хамгийн агуу нь болох болно.

Дөлгөөн сэтгэлтэй хүн эцэстээ тэнгэрийн оронд өндөр эрх мэдэлтэй, өргөн уудам газартай болж чадна. Учир нь тэдний сүнс сэтгэл нь амжилттай болсоноор бүхий л ажил үйлс нь сайн байж, Бурханы агуу хайрыг хүртэж, тэнгэрийн оронд үй олон тоолж баршгүй сүнснүүд үүрд мөнхөд тэднийг хүндлэх болно.

Хайрт итгэгч та бүхэн, Бурхан гэм нүгэлгүй, хорон муу зан чанаргүй ариун хүмүүст баярладаг бөгөөд сайхан сэтгэл, ариусал, сайн үйлсээр дүүрэн байж энэ ертөнцийн хүмүүсийг өвөрлөж, тэнгэрийн оронд ч хүртэл өөрийн гэр оронтой, агуу хүн болохыг Эзэний нэрээр хүсэн залбирч байна.


Монгол Манмин Төв Сүм

Мөргөлийн цаг

Мөргөл	Цаг
Их мөргөл	Ням гариг 10: 30
Үдээс хойшх мөргөл	Ням гариг 13: 40
3-дахь өдрийн мөргөл	3 дахь өдөр 18: 00
5-дахь өдрийн мөргөл	5 дахь өдөр 22: 00
Хүүхдийн мөргөл	ням гариг 10: 30
Сурагч залуучуудын мөргөл	Хагас сайн өдөр 16: 30

Залбирлын цаг

Ангилал	Цаг	Удирдагч
Даниел үүрийн залбирал	Даваа- баасан 05: 00- 06: 00	Ш. Золзаяа (Том хүний баг хариуцагч)
Даниел өдрийн залбирал	Даваа- баасан 09: 00- 10: 00	П. Уртнасан (2Том хүний баг хариуцагч)
Даниел оройн залбирал	Өдөр бүр 18: 30- 20: 00	П. Батзориг (Чуулганы хариуцагч)



Хаяг: Баянзүрх дүүрэг, 13-р хороолол 6-р хороо, ой булан- 6 иргэний А.О.С
Утас: чуулганы- 5525-7637 чуулганы хариуцагч- П. Батзориг 9117-0773

www.manmin.org
www.manmintv.org

Амьд оршигч Бурхантай уулзахыг хүсэж байна

Асуулт: Бурханы хүүхэд болсоны хувьд үргэлж Эцэг Бурхантай уулзаж, мэдэрсэн халуун итгэлийг олохыг хүсэж байна. Яавал амьд оршигч Бурхантай уулзаж болох вэ?

Хариулт: Бурхантай уулзах хамгийн чухал мөртөлөө гол үндсэн зүйл бол юун түүнд чин сэтгэлээсээ хүсэн тэмүүлэх явдал юм (Сургаал үгс 8:17). Бурхан хүнийг эхлээд хайрлаж, Өөрөө эхлээд хайдаг ч гэсэн бидний зүрх сэтгэлийн хаалгыг хүчээр нээж орж ирдэггүй. Тэр Өөрийнхөө шударга ёсны дагуу ажилладаг ба харин хүн өөрийн хүслээр сэтгэлийн хаалгаа нээж өгвөл Бурхан орж ирдэг (Илчлэлт 3:20). Юуны түүнд хүн сүнс дотроо ядуу буюу даруу болох үедээ Бурханыг хайвал уулзах боломжтой. Энэ мэт Бурхантай уулзах чин хүсэл тэмүүлэлтэй болж сэтгэлээ бэлдсэний дараа Бурханы амьд оршин буй газар луу явах хэрэгтэй юм. Одоо би та бүхэнд Гэрэл, Үнэн, Сайн үйлс, Хайр гэсэн 4 зүйлийн дунд оршин байдаг Бурхантай уулзах дөрвөн арга замыг хэлж өгье.

1 Бурханы үгийг дуулгавартай дагасанаар уулзаж болно.

Библийн 66 бүлэг ном нь бидэнд Бурхан гэж хэн болох, хүн төрөлхтөний төлөө Түүний хүсэл юу болохыг тодорхой айлдсан байдаг. Ялангуяа Бурхан бидэнд хичнээн их хайртай болохыг тэмдэглэгдсэн байдаг билээ. Үүнийг ойлгож ухаарах тусам Бурханд итгэх итгэл нь өсдөг ба бид цуглаанд ирж Бурханы үг сургаалийг сонсох нь амьд оршигч Бурхантай уулзахын тулд билээ.

Библи бол Ариун Сүнсний хүчээр бичигдсэн ном (Тимот 3:16) тул Ариун Сүнсний тусламжтайгаар

жинхэнэ утга учрыг ойлгож болдог. Тиймээс Бурханы Үг нь амьд, бидний сүнс сэтгэлийг өөрчлөх хүч чадалтай бөгөөд бүр Еврей 4:12 бичигдсэнээр биелэх болно.

Бурханы үгийг дуулгавартайгаар дагаж “Хий гэсэн зүйлийг нь хийж, бүү хий гэснийг нь хийхгүй байж, сахь гэсэн зүйлийг нь сахиж, хая гэснийг нь хаяж чадвал амьдралд тохиолдох бүхий л хүнд хэцүү асуудал шийдэгдэж, Бурханаас танд ивээл ерөөл дүүрэн бялхаж ирэх болно.

2 Чин сэтгэлээсээ, гал халуун залбирвал Бурхантай уулзаж чадна.

Бид Бурханд хандан Есүс Христийн нэрээр чин сэтгэлээсээ хичээнгүйлэн залбирвал Ариун сүнс бидэнд хүчийг өгч, Библийн үгэн дотор агуулагдаж байгаа Бурханы хүсэл сэтгэлийг ойлгон ухаарч чадна. Мөн түүгээр ч зогсохгүй Бурханы үгийн дагуу амьдрах хүч өгөгддөг.

Залбирал бол зүгээр л нэг ганц хүний яриа биш харин Бурхантай биечлэн ярилцаж байгаа харилцан яриа юм. Бурхан өөрийн хүүхэд бүрийн залбиралыг сонсож зүрх сэтгэлд нь хүрч ухаарлыг хайрладаг. Ийнхүү залбиралаар дамжуулан бид Бурхан Аавтай холбогдож, харилцаа тогтоож чадна. Өөрөөр хэлбэл, бид Бурхантай хувийн харилцаа тогтоож чаддаг. Цаашлаад бид Бурханы хүслийн дагуу залбирвал шударга ёсны хуулиар хариултаа авч, Түүнтэй заавал нүүр тулан уулзаж чадах болно.

Марк 10:46-52 ишлэлд сохор Бартимай Есүсийг үнэн

сэтгэлээсээ хайж, Түүнийг чангаар дуудан уулзаж хариултаа авч байгаа тухай гардаг. Есүстэй уулзахын тулд чанга дуугаар хашгиртал орчин тойрны хүмүүс дуугүй бай гэж зэмлэдэг боловч тэрээр бүр чангаар хашгирсаар л байдаг. Энэ нь тэр Есүстэй уулзах чин хүсэлтэй байсаных юм. Эцэст түүний хүслээр болж Есүстэй уулзаж өөрийн итгэлийн дагуу хараа орсон байдаг.

Библид Елиа, Петр зэрэг олон итгэлийн эш үзүүлэгчид чанга дуугаар залбирдаг тухай гардаг. Есүс хүртэл Гэтсэмэн ууланд бүх хүчээрээ хөлсөө цусан дусал болон газарт унатал залбирсан. Бид ч “Бурхантай уулзна” хэмээн сэтгэл шулуудан үнэн сэтгэлээр залбирах хэрэгтэй. Залбирахдаа бодол санаа болон нойрмоглол унтаа байдалд бус зөвхөн Бурхантай л уулзахыг хүсэн тэмүүлж залбирвал хүссэн хариултаа зайлшгүй авч чадна (Иеремиа 33:3).

3 Чин сэтгэлээсээ дуулсан магтан дуугаар Бурхантай уулзаж болно

Амьд Бурхан маань магтан дуунд үнэхээрийн их баярладаг. Дуулал 69:30-31-д “Би Бурханы нэрийг дуугаар магтаж, Түүнийг талархалаар өргөмжилнө. Энэ нь Эзэнд үхрээс илүүгээр, эсвэл эвэр туурайтай залуу бухнаас илүүгээр таалагдах болно” гэжээ.

Бурханы хүүхдүүд Аавдаа үзэсгэлэнтэй сайхан магтаалыг өргөхөд Түүний зүрх, нүд, чих Өөрийн хүүхдүүд рүү хандан баясдаг учир бид магтан дууг баяр хөөртэйгээр ивээл дүүрэн дуулдаг.

Библид үзвэл итгэлийн өвөг эцэг болсон олон эш үзүүлэгчид хүртэл Бурханд магтаалыг үргэлж өргөсөөр ирсэн. Тэдний нэг нь Давид юм. Давид ганцаараа хонио хариулахдаа, хаан болохдоо, Бурханд тахил өргөхдөө

ч үргэлж баяр хөөртэйгээр магтаал өргөдөг байлаа. Үүнд нь Бурхан Давидыг хайрлаж цаг үргэлж дэргэд нь байсан юм.

Давидын дуулсан магтаалд гэрлийн хүч байсан бөгөөд босоо ятга тоглоход 1 Самуел 16:23-д бичигдсэнчлэн Саулыг зовоож байсан муу сүнснүүд зайлж байсан. Хаадын дэд 3-р бүлэгт эш үзүүлэгч Елиша чавхдаст хөгжмийг сонсоод Ариун Сүнсний бялхам байдлыг өмсөн Бурханы үгийг дамжуулдаг. Тиймээс бид Бурханы хайр ивээл, сайн, хүч чадлыг зүрх сэтгэлээсээ магтан дуулж, магтаалыг өргөвөл Бурхан Эцэг баярлан хүлээн авч биднийг эргүүлээд илүү ихээр хайрлаж ивээдэг юм.

4 Чин сэтгэлээр сүнслэг мөргөл үйлдвэл Бурхантай уулзаж чадна.

Хуучин гэрээний үед итгэлийн өвөг эцэг болсон Абрахам, Исаак, Иаков нар өргөлөөр дамжуулан Бурхантай харилцаж байсан. Соломон хаан мянган тахилыг Бурханд өргөж Бурхантай уулзаж Бурханы мэргэн ухаан болон бүхий л ивээлийг Түүнээс авч байжээ. Өнөө үед буюу шинэ гэрээний үед мөн л мөргөлөөр дамжуулан Бурхантай уулзаж болох юм.

Иохан 4:24-д “Бурхан бол сүнс, Түүнд мөргөгчид нь сүнсээрээ, үнэнээр мөргөх ёстой” гэж айлдсан байдаг. Өөрөөр хэлбэл чин сэтгэлээр, сүнсээр өргөсөн мөргөл гэдэг нь Бурханы үг болох “Амийн талх”-г Ариун Сүнсний бялхам байдал дотор зүрх сэтгэлээсээ хүсэн тэмүүлж сонсохыг хэлж байгаа юм. Ингэж Бурханыг

хайрлах сэтгэлээр баяр хөөр, талархал, залбирал, магтаалыг өргөж, Бурханыг зөвөөр ойлгож, бүхий л бие, сэтгэлээ зориулан чин сэтгэлээсээ хийсэн мөргөл нь жинхэнэ өргөл болдог юм.

Энэ мэт чин сэтгэлээсээ Сүнс болон итгэлээ өргөсөн мөргөлийг өргөвөл дээрээс өгөгдөх Бурханы ивээлийг авч, Тэнгэрийн орны хүсэл тэмүүлэлээр дүүрч, илүү амар тайван, баяр баясгалантай байх болно. Эдгээр нь гарцаагүй амь амьдрал, амар тайваны эх үндэс болсон Бурхантай уулзаж буйн баталгаа юм. Энэ агуу их ивээл, хайрыг амьдралдаа сайтар сахин хамгаалж чадвал үргэлж бидэнтэй хамт байдаг Бурханыг мэдэрч, өдөр бүр Түүнтэй уулзаж чадна.



Хан Буг Хуг итгэгчий гэр бүл У Хён Жү ахлагчийн хамт (зүүн гар талаас Хан Буг Ху итгэгч, охин Ин Хэ, эхнэр Күсүчэн, У Хён Жү ахлагч, хүү Ин Сү)

Эхнэр бид хоёр хэлгүй дүлий юм. Малайз эхнэртэйгээ би 2008 онд гэрлэсэн. Удалгүй хөөрхөн охин хүү хоёртой болсон тэд маань жирийн сонголттой. Энэ бол Бурханы ивээл ба хайр билээ.

Хүү маань төрөөгүй байхдаа л үхэх эсвэл зүгээр л нэг ургамал шиг амьтан болох байв.

Би хоёр дахь хүүхдэд минь тохиолдсон өвчинөөр дамжуулан Бурханы агуу хайрыг мэдэрч, итгэлийг олж авсан юм.

2011 онд хоёр дахь хүү маань хэвлийд 6 сартай болсон байлаа. Эмч эхогоор хараад цавь, төмсөг, гэдэсний ивэрхийтэй хүүхэд байна. Гэдэсний ивэрхий нь дээшээ томорсны улмаас, цээжний хөндийн эрхтэнг тэлж өрцөө шахаад цээжний яс нь цуурсан байна. Өөр том эмнэлэг дээр очиж нарийн шинжилгээ хийлгэх хэрэгтэй

Хан Буг Ху итгэгч (Хэлгүй сонсголгүй хүмүүсийн цуглаан)

Миний хүү залбиралын хүчээр амьдарч, бүх өвчин нь эдгэрсэн.

гэв. Ингээд бид Их сургуулийн эмнэлэгт нарийн шинжилгээ хийлгэж оношлуулсан нь биднийг бүр ч их цочирдуулсан юм.

Гэдэсний ивэрхий нь маш их томорч зүрх нь байх ёстой газраасаа өөр газар байрласан, ивэрхий нь уушгийг нь дарсан байдалтай байсан. Ураг маш их аюултай байдалд байгаа бөгөөд хүүхэд зулбах эсвэл амьд төрсөн ч цаашид амьдрах боломжгүй, бүр үгүй юмаа гэхэд бүх насаараа яг ургамалтай л адилхан хүн болох байлаа.

Эхнэр бид хоёр гэртээ ирээд уйлж гунин, сэтгэлийн гүн хямралд орж өдөр хоногыг арайхан өнгөрөөж байв. Гэтэл хэлгүй сонсголгүй хүмүүсийн багийн дэд удирдагч багш бидэнд зөвлөгөө өгч, Эзэний өдрийг ариунаар сахих, аравны нэгийн өргөлийн талаар маш сайн тайлбарлаж өглөө. Тэр бас Бурхан яагаад бидний хүүхдийг хамгаалахгүй байгаа тухай ч хэлж өгсөн юм.

Яг тэр үед би Эзэний өдөр сахидаггүй бас өргөл ч өгдөггүй байсан юм. Гэвч би энэ бүгдийнхээ төлөө чин чин сэтгэлээсээ гэмшиж, Эзэний өдрийг ариунаар сахидаг болсон. Бас 2011 оноос хойшхи өгөөгүй байсан бүх аравны нэгээ тооцон Бурханд өргөл болгон өгсөн. Тэгээд Тэргүүн пасторын залбирлыг авсан юм.

2011 оны 8 сарын 22 нд Ин Сү хүү маань ямар ч аюулгүй сайн төрсөн. Гэхдээ нөгөө ивэрхийнээсээ болоод хагалгаа хийлгэж инкубатор орох шаардлагатай болсон.

2011 оны 10 сард хүүгийн маань бие маш их муудаж мөн л эмнэлэгт хэвтсэн боловч түүний өвчин нь хүндэрч гуурсан хоолойн багтраатай, уушигны тэлэлттэй, цусан дах биллирубину хэмжээ хэт ихэссэн, зүүн уушигны хөгжил дутуу, цус бүлэгнэж судасны үрэвсэлтэй болсон гэх мэтийн маш олон өвчтэй байлаа. Хэлгүй, дүлий бидний хувьд түүнийг асарч өсгөхөд амаргүй байлаа.

Бурханы хүчээр эдгэрч цоо эрүүл болсон.

Хэлгүй сонсголгүй хүмүүсийн багт ажиладаг У Хён Жү ахлагч бидний энэ байдлыг ойлгож бидэнд тусалж байлаа. Тэр бүтэн нэг жилийн турш хүүг маань Манмин Төв Сүмийн залбирлын цуглаанд авч явж түүний эрүүл мэндийн төлөө залбирч маш их санаа тавин, хайраараа асарч, өөрийгөө бүрэн зориулдаг байлаа. Эхнэр бид хоёр Даниел залбиралд очиж залбирдаг байв.

Ин Сү хүү маань Тэргүүн пасторын залбирал, гар алчуурын (Үйлс 19:11-12) залбиралаар хэд хэдэн удаагийн маш хүнд хэцүү хямралын үеийг даван гарч чадсан юм. Тэр үед сонсголгүй бид хоёрын хувьд эцэг эхийнхээ үүргээ бүрэн биелүүлж чадахгүй байгаадаа сэтгэл өвддөг байлаа. Биднийг хүч чадал, сэтгэл зүрхээрээ халамжилж байсан У Хён Жү ахлагчид талархаад баршгүй юм.

Энэ бүхний эцэст хүү маань Тэргүүн пасторын залбирлаар бие нь сайжирч бүх өвчин нь эдгэрч, цоо эрүүл болсон юм. Эрүүл саруул болсон хүү маань өнгөрсөн 3 сараас эхлэн цэцэрлэгт явдаг болсон. Үхэхээс өөр замгүй байсан хүүг минь амьдаруулсан Агуу хүчит Бурхан Эзэндээ бүх алдар магтаал талархалыг өргөж байна.



Үхлийн ирмэг дээр байсан Хан Буг Хугийн хүү Тэргүүн Пасторын залбиралаар эдгэрч, одоо эрүүл саруул өсөж байна.



Гадаад мэдээ

Кени Найроби Манмин сүм Гар алчуурын цуглаан

Алхаж ч чаддаггүй байсан 3 настай хүү

Одоо явдаг болжээ.

2013 оны 2 сарын 24ний өдөр Кени улсын Найроби Манмин Ариун Сүмд эдгэрэл ивээлийн гар алчуурын цуглан боллоо. И Жэй Руг Тэргүүн пасторын залбирч өгсөн гар алчуураар Жон Мён Ху пастор (Африкийн Есүс Христийн Нэгдсэн Ариун Сүмийн захирал) өвчтэй хүмүүсийн төлөө залбирч өгөхөд хорт хавдартай, дох, саа өвчин, сахуу, зүрхны өвчин, хараа муутай, шохойжилтой болон дискний өвчтэй маш олон хүмүүсийн өвчин эдгэрлээ.

Тэр дунд төрсөн цагаасаа хойш алхаж ч чаддаггүй байсан 3 настай хүүхэд залбиралын дараа ганцаараа явдаг болсон гайхамшигтай зүйл болжээ. Үүнийг харсан итгэгчид баяр хөөртэйгээр Бурханд магтаалыг өргөлөө.

Эдгэрсэн Рен Опой хүү сүмээс 7 км зайтай Маконгенид амьдардаг байжээ. Түүний ах Иан Ата дүүгээ дагуулж амралтын өдрөөр сүмрүү бусад өдрөө хичээлдээ явдаг байж. Харин гар алчуурын цуглаанд дүүтэйгээ ирж Жон пастораас гар алчуурын залбирал авсанаар эдгэрчээ. Хөрш айлын хүмүүс хүртэл хүүг алхаад явж буйг нь хараад “Энэ хүүхдэд юу тохиолдоо вэ? гэж гайхцгаажээ.

